

“ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС” ТӨҮГ



**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ
ОРШИХ “ХӨХ ДЭЛ”-ийн ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-004487

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 2550466

Улаанбаатар хот

2026 он

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ОРШИЛ	3
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	5
2.1. Төслийн нэр.....	5
2.2. Төсөл хэрэгжүүлэгч.....	5
2.3. Төслийн байршил	5
2.4. Уурхайн одоогийн байдал	6
2.5. Ил уурхай	7
2.6. Ордын геологийн нөөц.....	8
2.8.Уурхайн ажиллах горим	10
2.9. Уурхайн хүчин чадал, уулын ажлын төлөвлөлт	11
2.10.Дэд бүтэц	12
Уурхайн байгууламжууд	12
Цахилгаан хангамж	12
Усан хангамж	13
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	15
3.1 Физик газарзүй	15
3.2 Уур амьсгал	15
3.3 Гадаргын ус болон газрын доорх ус	15
3.4 Хөрсөн бүрхэвч.....	16
3.5 Ургамлан нөмрөг	16
3.6 Амьтны аймаг.....	17
3.7 Нийгэм эдийн засгийн үзүүлэлт:	17
БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	18
4.1 Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл:	18
4.2 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:	18
4.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:.....	18
4.4 Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл:.....	18
4.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл:	19
4.6 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:	19
БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	20
БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	22
6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	25
6.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	26
6.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	29
6.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	29
6.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	29
6.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	30
6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	33
6.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	36
6.10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө	38

2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ	
ЗАРДАЛ.....	39
ДҮГНЭЛТ.....	40
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	41

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	5
Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол.....	5
Хүснэгт 3. Ордын геолгийн нөөц.....	8
Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим	11
Хүснэгт 5. Ил уурхайн ажлын календарь төлөвлөгөө	11
Хүснэгт 6. Уурхайд орж ирэх уны хэмжээ /Уурхай тус бүрээр/.....	14
Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	22
Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	26
Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	29
Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	31
Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	35
Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	36
Хүснэгт 13. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө	38
Хүснэгт 14. 2026 оны БОМТ-нд зарцуулах нийт зардал	39

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Хөх дэл” хайлуур жоншны ордын байршлын тойм зураг.....	6
Зураг 2. “Хөх дэл” хайлуур жоншны ордын байршлын зураг	6
Зураг 3. Дүйцүүлэн нөхөн сэргээлт хийх талбайн байршлын зураг.....	27
Зураг 4. Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих талбайн байршил.....	28
Зураг 5. ОХШХөтөлбөрийн мониторингийн цэг	34

БҮЛЭГ 1. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Хөх дэл” нэртэй хайлуур жоншны орд төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ-ний тайлан боловсруулах аргачлал:

Хайлуур жоншны ордын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ.

Энэхүү төлөвлөгөөгөөр Дундговь аймгийн Баянжаргалан сумын “Хөх дэл”

хайлуур жоншны ордыг ашиглах үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй болон голлох сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ
2	Улсын бүртгэлийн дугаар		9019029071
3	Уурхайн нэр		“Хөх дэл” нэртэй хайлуур жоншны орд ашиглах төсөл
4	Ордын	Нийслэл/Хот/ Аймаг	Дундговь аймаг
5	байршил	Сум/Дүүрэг	Баянжаргалан
6	Ашигт малтмалын төрөл		Жонш
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		MV-004487
8	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Дундговь аймаг
9		Сум/Дүүрэг	Баянжаргалан
10		Баг/Хороо	1-р баг
11	Захирлын	Нэр	Захирал
12	хаяг	Гар утас	976-

2.1. Төслийн нэр

“Хөх дэл” нэртэй хайлуур жоншны ордыг ашиглах төсөл

2.2. Төсөл хэрэгжүүлэгч

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ


2.3. Төслийн байршил

“Зүүн үнэгт” нэртэй талбайд орших Хөх дэлийн хайлуур жоншны орд нь Улаанбаатар хотоос урд зүгт 330 км, Мандалговь хотоос зүүн зүгт 150 км, Баянжаргалан сумаас урд зүгт 35 км, Бор-Өндөрийн УБҮ-ээс баруун зүгт 170 км-т оршдог.


- Засаг захиргаа: Дундговь аймаг, Баянжаргалан сум
- Трапецийн номенклатур: L-48-96
- Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ: 92.5 га

Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол

Тусгай зөвшөөрлийн дугаар	Цэгийн дугаар	Өргөрөг			Уртраг			Талбайн хэмжээ, га
MV-004487	1	45 ⁰	30'	58.62"	107 ⁰	59'	08.49"	92.5
	2	45 ⁰	30'	58.62"	107 ⁰	58'	22.5"	
	3	45 ⁰	30'	41.62"	107 ⁰	58'	22.5"	
	4	45 ⁰	30'	41.62"	107 ⁰	58'	45.51"	
	5	45 ⁰	30'	15.62"	107 ⁰	58'	45.51"	
	6	45 ⁰	30'	15.62"	107 ⁰	59'	08.49"	



Зураг 1. “Хөх дэл” хайлуур жоншны ордын байршлын тойм зураг



Зураг 2. “Хөх дэл” хайлуур жоншны ордын байршлын зураг

2.4. Уурхайн одоогийн байдал

Тусгай зөвшөөрлийн талбайн ерөнхий мэдээлэл: Тусгай зөвшөөрлийг анх АМХЭГ-ын даргын 2007 оны 2-р сарын 9-ний 16 тоот тушаалаар Дундговь аймгийн

Баянжаргалан сумын нутагт Үнэгтэй нэртэй газар байрлах Хөх дэлийн хайлуур жоншны ордыг ашиглах MV-004487 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Монголросцветмет” ТӨҮГ-т анх 30 жилийн хугацаатайгаар олгосон байдаг.

Тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчимд ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдоогүй, төслийн үйл ажиллагаанд нөлөөлөх тусгай хэрэгцээний газар мөн олгогдоогүй, гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар болон бусад хэрэгцээний газруудтай ямар нэг давхцалгүй, эрх зүйн хувьд үйл ажиллагаа явуулахад ямар нэг саадгүй талбай болно.

2.5. Ил уурхай

2025 оны 12 сарын 15-ны байдлаар хүдрийн биет-1, 2, 3, 4, 5, 6, 9-р биетүүдэд ил уурхайн ухаш үүссэн бөгөөд хүдрийн битедийн нэрээр ил уурхайнуудыг нэрлэсэн. Эдгээр ил уурхайнууд нь 2024 оны 11 сарын 05-ны өдрийн байдлаар дараах хэмжээтэй байна. Үүнд:

- *Хүдрийн биет-1:* ухаш нь 1102-1124 м-ийн түвшин хүртэл суусан, уурхайн дээд ирмэгийн түвшин 1157-1160 м-т буюу 36-55 м гүнтэй, баруунаас хойноос зүүн урагш 350 м урт сунасан, зүүн хойноос баруун урагш 120 м өргөнтэй, 3.9 га талбайг хамарсан ухаш үүсээд байна.
- *Хүдрийн биет-2, 5:* уурхай нь дээд түвшингүүдэд холбогдсон тээврийн тээврийн траншей бүхий нийлсэн нэг ухаш үүссэн байна. Энэ хэсгийн ухаш нь хүдрийн биет 2 дээр 1123-1135 м, хүдрийн биет 5 дээр 1109-1123 м-ийн түвшин хүртэл суусан, уурхайн дээд ирмэгийн түвшин 1158-1168 м-т буюу хүдрийн биет 2 хэсэгт 38 м хүртэл гүнтэй, хүдрийн биет 5 хэсэгт 52 м хүртэл гүнтэй, баруунаас зүүн тийш 450 м урт сунасан, 108-134 м өргөнтэй, 5.6 га талбайг хамарсан ухаш үүсээд байна.
- *Хүдрийн биет-3:* ухаш нь 1133 м-ийн түвшин хүртэл суусан, уурхайн дээд ирмэгийн түвшин 1165-1168 м-т буюу 35 м гүнтэй, баруунаас хойноос зүүн урагш 155 м урт сунасан, зүүн хойноос баруун урагш 72 м өргөнтэй, 0.6 га талбайг хамарсан ухаш үүсээд байна.
- *Хүдрийн биет-4:* ухаш нь 1124 м-ийн түвшин хүртэл суусан, уурхайн дээд ирмэгийн түвшин 1155-1163 м-т буюу 31-39 м гүнтэй, баруунаас хойноос зүүн урагш 200 м урт сунасан, зүүн хойноос баруун урагш 110 м өргөнтэй, 2.2 га талбайг хамарсан ухаш үүсээд байна.
- *Хүдрийн биет-6:* ухаш нь 1126 м-ийн түвшин хүртэл суусан, уурхайн дээд ирмэгийн түвшин 1161 м-т буюу 35 м гүнтэй, баруунаас хойноос зүүн урагш 235 м урт сунасан, зүүн хойноос баруун урагш 90 м өргөнтэй, 1.8 га талбайг хамарсан ухаш үүсээд байна.
- *Хүдрийн биет-9:* ухаш нь 1132 м-ийн түвшин хүртэл суусан, уурхайн дээд ирмэгийн түвшин 1155 м-т буюу 23 м гүнтэй, ойролцоогоор уртаашаа 142м өргөөшөө 95 м хэмжээтэй, 1.75 га талбайг хамарсан ухаш үүсээд байна.

Уурхайн үйл ажиллагаагаар уурхайн ухаш, хөрс, хүдрийн овоолго, барилга байгууламж зэрэгт нийт 51.2 га талбай өртсөн байдалтай байна.

2.6. Ордын геологийн нөөц

Хөх дэлийн хүдрийн талбайд хайгуулын ажлаар нийтдээ флюоритийн 30 гаруй биет ялгаж 7 бүст ангилснаас 20 биет нь кондицийн шаардлага хангасан гэж үзсэн байдаг. Хэлбэр болон технологийн шинж чанараар нь хүдрийн биетүүдийг хоёр групп болгон ялгасан байдаг.

Хөх дэлийн жоншны ордод 2003-2005 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн, АМГТХЭГ-ын даргын 2008 оны 02 дугаар сарын 12-ний өдрийн 46 дугаар тушаал, ЭБМЗ-ийн 2008 оны 01 дугаар сарын 29-ний өдрийн 02-3 дугаар тоот дүгнэлтээр жоншны хүдрийн нөөцийг бодитой /В/ зэргээр 899.4 мян.т, боломжтой /С/ зэргээр 305.8 мян.т-оор тус тус тогтоон нийт 1,205.2 мян.т нөөцийг улсын нөөцийн санд бүртгэсэн байдаг.

Тус ордыг ил аргаар 2010 оноос эхлэн олборлолт явуулсан бөгөөд уулын ажлын мэдээ, тайлангаар ордын ашиглалтын хугацаанд бодитой В зэрэглэлээр 496.9 мян.т, боломжтой С зэрэглэлээр 121.3 мян.т, нийт 618.2 мян.т жоншны хүдрийн нөөцийг олборлож 2023 оны 01-р сарын 01-ны өдрийн байдлаар бодитой В зэрэглэлээр 402.5 мян.т, боломжтой С зэрэглэлээр 184.6 мян.т, нийт 587.1 мян.т нөөцийн үлдэгдэлтэй байна гэж тооцсон тус нөөцөд тулгуурлан 2023 онд ТЭЗҮ-ийн тодотгол-1-ийг боловсруулсан байдаг.

Хүснэгт 3. Ордын геологийн нөөц

Анхны геологийн нөөц					Үлдэгдэл нөөц (2025.01.01)		
Хүдрийн биетийн дугаар	Нөөцийн зэрэг	Хүдрийн хэмжээ	CaF ₂	Эрдсийн хэмжээ	Хүдрийн хэмжээ	CaF ₂	Эрдсийн хэмжээ
		тн	%	тн	тн	%	тн
1-р хүдрийн биет	В-1-1	51,124.5	40.3	20,603.2	1,330.0	42.86	570.0
	В-1-2	63,277.4	47.9	30,328.9	6,430.0	72.63	4,670.0
	В-1-3	1,944.0	37.8	735.8	120.0	8.33	10.0
	В-1-4	73,700.2	47.2	34,786.5	30,780.0	46.88	14,430.0
	В-1-5	52,105.8	46.1	24,005.2	22,440.0	43.98	9,870.0
	В-1-6	41,399.1	45.5	18,824.2	17,940.0	46.21	8,290.0
	В-1-7	20,374.2	35.0	7,128.9	7,940.0	34.01	2,700.0
	С-1-1	8,820.9	36.4	3,209.0	11,400.0	36.23	4,130.0
	С-1-2	3,815.1	35.7	1,361.2	4,400.0	43.59	1,918.0
	С-1-3	18,932.9	45.3	8,582.3	5,720.0	52.90	3,026.0
	С-1-4	6,674.4	50.5	3,369.2	6,940.0	52.31	3,630.0
	Нийт В	303,925.2	44.9	136,412.7	86,980.0	46.61	40,540.0
	Нийт С	38,243.3	43.2	16,521.7	28,460.0	46.25	12,704.0
	Нийт В+С	342,168.6	44.7	152,934.4	123,440.0	43.13	53,244.0
2-р хүдрийн биет	В-2-1	29,330.1	46.1	13,521.2	2,610.0	21.80	460.0
	С-2-1	35,356.5	49.4	17,462.6	15,870.0	55.45	8,800.0
	С-2-2	13,766.9	58.9	8,111.5	4,620.0	87.44	4,040.0
	С-2-3	16,054.2	32.1	5,148.6	10,390.0	26.18	2,720.0
	Нийт В	29,330.1	46.1	13,521.2	2,110.0	21.80	460.0
	Нийт С	65,177.6	47.1	30,722.7	30,880.0	50.38	15,560.0
	Нийт В+С	94,507.7	46.8	44,243.9	32,990.0	48.56	16,020.0
3-р хүдрийн биет	В-3-1	33,161.2	44.0	14,594.3	33,160.0	44.0	14,590.0
	В-3-2	44,516.6	42.4	18,857.2	44,434.0	42.3	18,796.0
	С-3-1	1,399.1	33.8	472.3	1,399.0	33.7	472.0
	С-3-2	2,019.9	35.5	717.1	2,020.0	35.5	717.0
	С-3-3	2,203.2	44.4	978.2	2,203.0	44.4	978.0
	С-3-4	9,262.5	25.7	2,378.6	9,262.0	25.7	2,379.0
	С-3-5	4,995.5	44.1	2,205.5	4,996.0	44.2	2,206.0
	С-3-6	1,881.9	34.1	641.5	1,882.0	34.1	641.0
	Нийт В	77,677.8	43.1	33,451.5	77,595.0	43.0	33,390.0

	Нийт С	21,762.1	34.0	7,393.2	21,762.0	34.0	7,393.0
	Нийт В+С	99,439.9	41.1	40,844.7	99,357.0	41.0	40,783.0
4-р хүдрийн биет	В-4-1	52,420.3	52.1	27,311.0	-	-	-
	С-4-1	18,604.1	47.7	8,877.9	4,620.0	57.58	2,660.0
	С-4-2	90,530.2	48.4	43,852.8	24,530.0	39.38	9,661.0
	С-4-3	17,410.1	38.2	6,655.9	5,090.0	38.51	1,960.0
	Нийт В	52,420.3	52.1	27,311.0	-	-	-
	Нийт С	126,544.4	46.9	59,386.6	34,240.0	41.71	14,281.0
	Нийт В+С	178,964.7	48.4	86,697.6	34,240.0	41.71	14,281.0
5-р хүдрийн биет	В-5-1	35,813.3	34.9	12,495.3	12,820.0	22.62	2,900.0
	В-5-2	62,914.7	38.4	24,127.8	29,430.0	31.53	9,280.0
	В-5-3	127,419.2	34.3	43,641.7	58,820.0	35.75	21,030
	В-5-4	119,918.8	32.7	39,153.5	44,740.0	37.68	16,860.0
	С-5-1	3,666.1	34.9	1,280.2	3,670.0	34.88	1,280.0
	С-5-2	19,259.9	36.3	6,991.3	19,260.0	36.29	6,990.0
	Нийт В	346,066.1	34.5	119,418.3	145,810.0	34.34	50,070.0
	Нийт С	22,926.0	36.1	8,271.5	22,930.0	36.07	8,270.0
	Нийт В+С	368,992.0	34.6	127,689.8	168,740.0	34.57	58,340.0
6-р хүдрийн биет	В-6-1	5,881.7	39.9	2,349.1	2,340.0	34.19	800.0
	В-6-2	27,803.6	50.1	13,918.5	17,180.0	57.57	9,890.0
	В-6-3	29,733.2	52.5	15,606.9	19,590.0	62.89	12,320.0
	С-6-1	3,280.5	48.2	1,579.9	3,280.0	48.17	1,580.0
	С-6-2	2,409.8	42.0	1,012.8	2,410.0	41.91	1,010.0
	Нийт В	63,418.5	50.3	31,874.5	39,110.0	58.83	23,010.0
	Нийт С	5,690.3	45.6	2,592.7	5,690.0	45.52	2,590.0
	Нийт В+С	69,108.7	49.9	34,467.2	44,800.0	57.14	25600.0
7-р хүдрийн биет	С-7-1	708.8	35.8	253.8	708.0	35.9	254.0
	С-7-2	5,589.3	47.7	2,663.3	5,589.0	47.6	2,663.0
	С-7-3	6,544.1	51.1	3,341.4	6,518.0	50.9	3,320.0
	С-7-4	364.5	36.3	132.4	364.0	36.3	132.0
	С-7-5	1,360.8	39.2	533.2	1,361.0	39.2	534.0
	С-7-6	2,138.4	43.4	927.9	2,138.0	43.4	928.0
	Нийт С	16,705.8	47.0	7,852.0	16,678.0	47.0	7,831.0
9-р хүдрийн биет	В-9-1	11,608.4	31.1	3,605.6	7,050.0	29.65	2,090.0
	В-9-2	14,934.4	36.2	5,400.3	11,470.0	35.14	4,030.0
	С-9-1	2,421.9	30.8	745.0	2,420.0	30.58	740.0
	С-9-2	6,368.6	38.4	2,445.6	6,370.0	38.30	2,440.0
	Нийт В	26,542.8	33.9	9,005.9	18,520.0	33.05	6120.0
	Нийт С	8,790.5	36.3	3,190.6	8,790.0	36.18	3180.0
	Нийт В+С	35,333.3	34.5	12,196.5	27,310.0	34.05	9300.0
Ордын нийт	Нийт В	899,380.7	41.3	370,995.1	370,625.0	41.49	153,590.0
	Нийт С	305,840.0	44.4	135,931.0	169,430.0	42.38	71,809.0
	Нийт В+С	1,205,220.7	42.1	506,926.1	540,055.0	41.77	225,399.0

2.7. Ил уурхайн ашиглалтын систем үйлдвэрлэлийн нөөц

Уул-геологи, уул-техникийн нөхцөл

“Хөх Дэл” уурхайн олборлолтод нийт 7 хүдрийн биет өртөх бөгөөд хүдрийн биетийн зузаан, гүн уналын өнцөг зэргээс хамааран уурхай бүр харилцан адилгүй үүсэх бөгөөд уурхайн гүн 25-52 м ба хил хязгаар нь давхаргын хэмжээгээр тодорхойлогдоно.

2003-2005 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын судалгаагаар 50-75 м гүн цооногуудыг өрөмдсөн бөгөөд тус цооногуудын мэдээллээр ордын хэмжээнд ус илрээгүй бөгөөд гүний усны түвшин 75 м-ээс доош байх боломжтой гэж үзсэн байдаг.

Уул-техникийн нөхцөлийн хувьд хөрсний ус, гүний ус, хөлдөлт зэрэг аливаа хүндрэлгүй.

Ашиглалтын систем

2026 онд ордыг ил аргаар, авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглана.

Ил уурхайн талбай: 2026 оны ашиглалтын дараа ил уурхайн эцсийн хүрээ хязгаар дараах байдалтай байна. Үүнд:

- *Хүдрийн биет-1:* баруунаас хойноос зүүн урагш 350 м урт сунасан, зүүн хойноос баруун урагш 120 м өргөнтэй, 3.9 га;
- *Хүдрийн биет-2, 5:* баруунаас зүүн тийш 450 м урт сунасан, 100-120 м өргөнтэй, 5.1 га;
- *Хүдрийн биет-3:* баруунаас хойноос зүүн урагш 110 м урт сунасан, зүүн хойноос баруун урагш 72 м өргөнтэй, 0.6 га;
- *Хүдрийн биет-4:* баруунаас хойноос зүүн урагш 200 м урт сунасан, зүүн хойноос баруун урагш 110 м өргөнтэй, 2.2 га;
- *Хүдрийн биет-6:* баруунаас хойноос зүүн урагш 235 м урт сунасан, зүүн хойноос баруун урагш 90 м өргөнтэй, 1.8 га;
- *Хүдрийн биет-9:* ойролцоогоор 122х95 м хэмжээтэй, 1.7 га;

Ил уурхайн гүн: 2026 оны ашиглалтын дараа ил уурхайн ёроолын хамгийн нам түвшин нь дараах байдалтай байна. Үүнд:

- *Хүдрийн биет-1:* 1102 м-ийн түвшин хүртэл суусан, уурхайн дээд ирмэгийн түвшин 1157-1160 м-т буюу 55-58 м гүнтэй;
- *Хүдрийн биет-2, 5:* хүдрийн биет 2 дээр 1113 м, хүдрийн биет 5 дээр 1109 м-ийн түвшин хүртэл суусан, уурхайн дээд ирмэгийн түвшин 1158-1168 м-т буюу хүдрийн биет 2 хэсэгт 45 м хүртэл гүнтэй, хүдрийн биет 5 хэсэгт 59 м хүртэл гүнтэй;
- *Хүдрийн биет-3:* 1127 м-ийн түвшин хүртэл суусан, уурхайн дээд ирмэгийн түвшин 1165-1168 м-т буюу 38-41 м гүнтэй;
- *Хүдрийн биет-4:* 1119 м-ийн түвшин хүртэл суусан, уурхайн дээд ирмэгийн түвшин 1155-1163 м-т буюу 36-44 м гүнтэй;
- *Хүдрийн биет-6:* ухааш нь 1126 м-ийн түвшин хүртэл суусан, уурхайн дээд ирмэгийн түвшин 1161 м-т буюу 35 м гүнтэй;
- *Хүдрийн биет-9:* ухааш нь 1122 м-ийн түвшин хүртэл суусан, уурхайн дээд ирмэгийн түвшин 1155 м-т буюу 33 м гүнтэй

Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаал буюу “АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЛАГ, ОРДЫН НӨӨЦИЙН АНГИЛАЛ, ЗААВАР”-ын дагуу бодитой (В) нөөцийг олборлоно. Ашиглалтын үед зайлшгүй өртөх боломжтой (С) зэрэглэлийн нөөцийг үйлдвэрлэлийн нөөцийн (I бүлэг) В' зэрэглэлд шилжүүлэн үйлдвэрлэлийн нөөцийг тооцсон. Үйлдвэрлэлийн нөөцийг тооцохдоо уул-техникийн нөхцөл, ашигт малтмалын онцлог зэргээс шалтгаалж ашиглалтын үеийн хаягдал 3.9%, бохирдол 8%-тай олборлохоор тооцсон.

Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор ашиглалтын хугацаанд нийт 36.9%-ийн дундаж агуулгатай 320.2 мян.тн хүдэр олборлоно.

2.8. Уурхайн ажиллах горим

2026 онд Хөх дэлийн уурхай нь 1-р сараас 12-р сарын хооронд тасралтгүй ажиллах бөгөөд жилд ажиллах боломжит 365 хоногоос дараах хугацааг хорогдуулан уурхайн жилд ажиллах цэвэр хугацааг тооцлоо. Үүнд:

- Монгол улсын хууль тогтоомжуудад заасны дагуу нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд заасны дагуу амралтын 16 хоног;
- Цаг агаарын саатал 24 хоногийг хасч тооцсоноор уурхайн жилд ажиллах цэвэр хугацааг 325 хоног байхаар тооцлоо.

Уурхай нь хоногт 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байх бөгөөд цайны цаг, ээлжийн бэлтгэл төгсгөл цаг зэргийг хасч тооцсоноор ээлжинд ажиллах цэвэр хугацаа 10 цаг байхаар тооцлоо. Уурхайн ээлжийн цаг ашиглалтын коэффициент 0.83, жилд 3237 цаг ажиллах хязгаартай байна.

Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим

№	Үндсэн ажиллагаа	Хэмжих нэгж	Газрын дээр
1	Хуанлийн өдөр (3,15-11,15)	Хоног	365
2	Баяр ёслолын амралт	Хоног	16
3	Цаг агаарын хүндрэл	Хоног	24
4	Жилд ажиллах хоног	Хоног	325
5	Жилд ажиллах цаг	Цаг	3237
6	Хоногт ажиллах ээлж	Ээлж	1
7	Ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	12

2.9. Уурхайн хүчин чадал, уулын ажлын төлөвлөлт

2026 онд 163.5 мян.м³ хөрс хуулж, 65.0 мян.т хүдэрт 35.2%-ийн агуулгатай 22.9 мян.т металл олборлоно. Хөрс хуулалтын дундаж коэффициент ордын дунджаар $K_{хд}=2.5$ м³/т байна.

Хүснэгт 5. Ил уурхайн уулын ажлын календарь төлөвлөгөө

Хүдрийн биет	Уурхайн нэр	Хөрс хуулалт, мян.м ³	Үйлдвэрлэлийн нөөц			K _{хд}
			Хүдэр, мян.т	Агуулга, %	Металл, мян.т	
Хүдрийн биет-1	Уурхай-1	14.5	5.4	34.8	1.9	2.7
Хүдрийн биет-2	Уурхай-2	32.8	13.8	34.3	4.7	2.4
Хүдрийн биет-3	Уурхай-3	59.6	23.4	37.9	8.9	2.6
Хүдрийн биет-4	Уурхай-4	11.9	4.8	34.6	1.7	2.5
Хүдрийн биет-5	Уурхай-5	27.2	9.5	33.3	3.2	2.9
Хүдрийн биет-9	Уурхай-9	17.7	8.1	32.5	2.6	2.2
НИЙТ		163.5	65.0	35.2	22.9	2.5

Гар аргаар ангилан ялгах, хүчин чадал

2026 онд 65 мян.т хүдэр олборлохоор төлөвлөсөн. Тус ордоос ашиглалтын жилд хугацаанд 35.4%-н дундаж агуулгатай 65.0 мянган тонн хайлуур жоншны хүдрийг олборлон 25 мм-ийн тороор шигшин, +25 мм-ийн бүтээгдэхүүнийг гар ялгалтаар ялгаж ФК-75 маркийн бүхэллэг жонш, бага агуулгатай хүдэр гэсэн бүтээгдэхүүн гаргаж авна.

Баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалтын тооцоо

2026 онд 35.2%-ийн дундаж агуулгатай 65 мянган тонн хайлуур жоншны хүдрийг олборлон 25 мм-ийн тороор шигшин, +25 мм-ийн бүтээгдэхүүнийг гар ялгалтаар ялгаж 71.9%-ийн агуулгатай 9.38 мянган тонн бүхэллэг жонш экспортлох бөгөөд 33.0%-ийн агуулгатай 20.88 мянган тонн баяжмал, 25.15%-ийн агуулгатай 34.74 мянган тонн нунтаг

хүдрийн баяжмал ялган Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн хүдрийн овоолгод овоолно.

2.10. Дэд бүтэц

Хөх дэлийн ордыг 2010 оноос олборлож эхлэсэн тул шаардлагатай дэд бүтэц болох уурхайн цахилгаан хангамж, ус хангамж, дулаан хангамж, хотхоны барилга болон гадаад, дотоод тээврийн зам, харилцаа холбоо зэргийг бүрэн шийдсэн.

Уурхайн байгууламжууд

Оффис, хотхон: Уурхайн тосгон нь уурхайн баруун талд байрлах бөгөөд 1.55 га талбай газарт байгуулагдсан. Тосгон нь ажилчдын амрах гэр, хоолны газар, агуулах, харуулын байр, худаг, хог хаягдлын цэг, эмнэлгийн байр зэрэг байгууламжуудаас бүрдэнэ. Уурхайн ажилчдын байр нь хотхоны баруун болон баруун хойд хэсэгт байрлах бөгөөд 8 гэрээс бүрдэнэ. Оффис, цайны газар, эмнэлгийн байр зэрэг нь 1 давхар 2 байгууламжаас бүрдэнэ.

Засварын газар, сэлбэгийн агуулах: Уурхайн техникүүдийн засвар, үйлчилгээг чанаржуулж сайжруулах зорилгоор 2016 онд Бор-Өндөр УБҮ-ээс ангар зөөвөрлөн авчирч граж, засварын зориулалтаар барьж ашиглалтанд оруулсан. Засвар үйлчилгээний цэг нь тосгоны баруун хойд талд 50 метрийн зайд байрлах ба засварын хэсэг, сэлбэг материалын болон шатах тослох материалын агуулах зэргээс үүснэ.

Шатах тослох материалын агуулах: Уурхай нь жилд дизелийн түлш 201.5 мян.л, тос, масло 6 мян.л, хөргөлтийн шингэн 250 л тус тус хэрэглэнэ. Уурхайн техникүүд нь дизель түлшээр ажилладаг тул ШТМ-ыг 10 хоногийн нөөцтэй байхаар тооцож түлшинд 20 т-ын багтаамжтай ган торх 1 ширхэгийг байршуулж ашиглаж байна.

ШТМ-ын агуулахыг орон нутгийн болон бусад хяналтын байгууллагуудын байцаагчдын тавьсан шаардлагад нийцүүлэн байнга шинэчлэн засварлаж, галын аюулгүй байдал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм, дүрэм журмын дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор тоноглогсон.

Хамгаалалтын далан, шуудуу: Уурхайд гадны хөдөлгөөнөөс хамгаалах, тусгаарлах зориулалттай 2.9 км урт далан болон шуудуутай. Далан нь 1.5 м өндөр ба 3 м өргөн суурьтай, хажуу нь 45 градусын налуутай бөгөөд хамгаалалтын даланг байгуулахад хөрс хуулалтын явцад гарах чулуулгийг ашигласан. Хөх Дэл хайлуур жоншны уурхай болон бусад барилга байгууламжууд нь шалган нэвтрүүлэх харуулын байр болон хашаагаар хүрээлэгдсэн.

Ангилах хэсэг: нь 1-р уурхайн баруун талд байрлах хөрсний овоолгын хажууд байрлах бөгөөд үйлдвэрийн тоног төхөөрөмж, хүдрийн овоолго, баяжмалын овоолгуудаас бүрдэнэ. Бутлан ангилах үйлдвэр нь нийт 1 га талбайд байрлах ба 2026 онд 4-р уурхайн хойд талын овоолгод нүүлгэн шилжүүлж суурилуулахаар төлөвлөөд байна.

Цахилгаан хангамж

Цахилгаан хэрэглэгчид: Уурхайн ашиглалтын үед цахилгааны дараах үндсэн хэрэглэгч байна. Үүнд:

- *Уурхайн кемпийн хэрэглэгчид:* Уурхайн захиргаа аж ахуйн байр, ажилчдын байр, цайны газар;

- *Бусад хэрэглэгчид:* Засварын газар, ШТС;

Хөх дэлийн хайлуур жоншны ордын ойролцоо цахилгаан дамжуулах шугам сүлжээ, хүрэлцээ байхгүй тул уурхайн цахилгаан хэрэглэгчдийг дизель генератораар хангадаг. Мөн уурхайн цахилгаан хэрэглэгчдийн суурилагдсан чадал болон цахилгаан хэрэглээ бага тул дизель генератораар шийдэрлэж ирсэн.

Уурхайн нийт цахилгаан хэрэглэгчдийн суурьлагдсан чадал 200.9 кВа, ил уурхайн цахилгаан хэрэглэгчдийн тооцооны бүрэн чадал 160.5 кВа байна.

67.9 кВа, бусад цахилгаан хэрэглэгчдийн тооцооны бүрэн чадал 92.6 кВа байгаа тул үүнд тохирсон генераторуудын хэрэглэж байна.

Усан хангамж

Уурхай нь технологийн усны хэрэгцээ байхгүй бөгөөд ахуйн хэрэгцээний усыг гүний худгаас зөөврөөр хангана. Зүүн үнэгт талбайн ил уурхай нь Монгол орны усны сав газрын Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт хамаарна.

Усны хэрэглээ: Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын яамны сайдын 2015 оны А/301 дугаар тушаалын дагуу усны тооцоог гаргав.

- ✓ Унд ахуйн усны хэрэглээ: $30\text{хүн} \times 30\text{л/хон} \times 325\text{хон} = 292,5 \text{ м}^3/\text{жил}$

Уурхайн ажилчдын унд ахуйн усны хэрэглээний усанд шаардлагатай $0.9\text{м}^3/\text{хоног}$ усыг өөрийн эзэмшдэг 0.2 л/сек ($17.28 \text{ м}^3/\text{хоног}$) ундрагатай худгаас хангахад хүрэлцээтэй байна. Мөн нэг ээлжид 30 хүн ажиллахаар тооцсон болно.

- ✓ Зам талбайн тоосжилт дарах усны хэрэглээ:

$$40.000\text{м}^2 \times 2\text{л} = 80.0\text{м}^3/\text{хоног} \times 100 (\text{тоосжилт дарах хоног}) = 800.0\text{м}^3/\text{жил}$$

- ✓ Ногоон байгууламжийн усалгаа: $500\text{ш} \times 40\text{л} = 16.0\text{м}^3/\text{хоног} \times 117 (\text{удаа}) = 2,340 \text{ м}^3/\text{жил}$

2026 онд 500ш суулгацыг уурхайн кемп орчимд суулгахаар төлөвлөсөн болно.

Нийт усны хэрэглээ: $3,432.5\text{м}^3/\text{жил}$

Ил уурхайн шүүрлийн усны тооцоо:

“Хөх дэл” хайлуур жоншны ордын Зүүн үнэгт талбайд олборлолт явуулж буй 1, 5-р уурхайд газрын доорх усны шүүрэлт гарч байна. Эдгээр уурхайл ашиглалтын 30 метрийн гүнээс газрын доорх ус илэрч байна.

Уурхайн геологи хайгуул, ашиглалтын үеийн нөхцөл байдалтай уялдуулан газрын доорх усны уст давхаргыг хамгийн багаар буюу 30 м –ээр сонгов.

Ил уурхайн шүүрлийн уснаас ашиглаж болох усны хэмжээг гидродинамикийн арга дээр тулгуурлан “Их худгийн” томъёогоор тодорхойлбол:

$$Q = \frac{1.36 \times k(2H-S)S}{\lg \frac{R+r_0}{r_0}}$$

k – шүүрэлтийн итгэлцүүр, м/хоног. $k = 0.1 \text{ м/хоног}$

H – уст давхаргын зузаан, м. $H = 30.0 \text{ м}$

R – нөлөөллийн радиус, м

r_0 – Усажсан талбайн хэмжээ, м

$$R = 2S\sqrt{KH} = 2 \times 30 \times \sqrt{(0.1 \times 30)} = 104 \text{ м}$$

$$r_0 = \sqrt{\frac{A}{\pi}}$$

Хүснэгт 6. Уурхайд орж ирэх усны хэмжээ /Уурхай тус бүрээр/

	Уурхай 1	Уурхай 5
Усажсан талбайн хэмжээ, м ²	1056	337
r ₀ , м	18	10
Шавхан зайлуулах усны хэмжээ, м ³ /хон	148	117
Шавхан зайлуулах усны хэмжээ, л/сек	1.7	1.3

Уурхай 1 –д орж ирэх усны хэмжээ

$$r_0 = \sqrt{\frac{A}{\pi}} = \sqrt{\frac{1056}{3.14}} = 18 \text{ м}$$

$$Q = \frac{1.36 \times k(2H-S)S}{lg \frac{R+r_0}{r_0}} = \frac{1.36 \times 0.1 \times (2 \times 30 - 30) \times 30}{lg \frac{104+18}{18}} = 148 \text{ м}^3/\text{хон буюу } 1.7 \text{ л/сек}$$

Уурхай 5 –д орж ирэх усны хэмжээ

$$r_0 = \sqrt{\frac{A}{\pi}} = \sqrt{\frac{337}{3.14}} = 10 \text{ м}$$

$$Q = \frac{1.36 \times k(2H-S)S}{lg \frac{R+r_0}{r_0}} = \frac{1.36 \times 0.1 \times (2 \times 30 - 30) \times 30}{lg \frac{104+10}{10}} = 117 \text{ м}^3/\text{хон буюу } 1.3 \text{ л/сек}$$

Уурхайд орж ирж буй ус чанар, найрлагын хувьд тоос дарах, ногоон байгууламжийн усалгаа болон байгальд шууд нийлүүлэхэд дотоодын болон Олон Улсын стандарт хэмжээнд нийцнэ.

Уурхайн шүүрлийн ус болон кемпийн худгийн ус ижил шинж чанартай буюу ан цав хагашрлын бүсэд агуулагдах газрын доорх ус байна.

Гашуун булгийн усны найрлага катионы хувьд шүүрлийн уснаас өөр шинж чанартай байна.

Уурхайд орж ирэх усны дийлэнх нь зэргэлдээх уст давхарга болон хур тунадас, конденсацийн усаар тэжээгдэж буй ан цавын уст давхаргын ус байна.

Уурхайд орж ирэх усны хэмжээ 1.3-1.7 л/сек байна.

Дулаан хангамж: Уурхайн жилийн ажлын үргэлжлэх хугацаа 325 хоног тул захиргаа аж ахуйн байр, ажилчдын амрах байр зэргийг шаардлагатай үед ердийн галлагаагаар дулаан хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ.

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1 Физик газарзүй

Дундговь аймаг нь Монгол орны физик-газарзүйн мужлалаар Говийн их мужийн Алтайн ар говийн мужийн Нууруудын хөндий тойрог, Хангайн өмнөд бэгэлцгийн тойрог, Дорнод говийн мужийн Умарт талын гүвээт талын тойрог, Монголын Дорнод талын их мужийн Халхын Дундад ба Дарьгангын талархаг мужийн Ухаа Гүвээт Халхын дундад тал тойрогт багтаж байна.

Төсөл хэрэгжиж буй Баянжаргалан сумын Зүүн үнэгт нэртэй талбай нь Говийн их мужийн Дорнод говийн мужийн Умарт талын гүвээт талын тойрогт тус тус багтаж байна.

Дундговь аймгийн өндөржилт нь далайн түвшинээс дээш 1100-1350 метрт өргөгдсөн, нутгийн хамгийн өндөр цэг нь 1926 м өндөрт орших Дэлгэрхангай уул бөгөөд Их, Бага газрын чулуу зэрэг уулс бий. Тус аймгийн газрын гадарга нь хэсэгчилсэн уулс, говь тал хөндий хоолой, дов толгод хосолсон, газрын гадаргад үндсэн чулуулаг ойрхон байдаг учир толгодын оройгоор ил гарч хад хэлбэрийг үүсгэж байгалийн сонин тогтоцыг үүсгэсэн газар нутаг элбэгтэй.

Хөх дэлийн хайлуур жонш олборлох ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь гадаргуугийн хувьд зүүнээсээ баруун тийш тусам өндөршсөн. Төслийн талбай нь далайн түвшнээс дээш 1100-1200 м-ийн өндөрт өргөгдсөн, газрын гадаргын хувьд, тал хээрийн жижиг толгод бүхий гүвээрхэг гадаргуутай байна.

3.2 Уур амьсгал

Төсөл хэрэгжих Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг Зүүн үнэгт нэртэй талбайд байрлах төслийн талбайн 2019-2021 оны сарын дундаж агаарын температур, хур тунадас, салхины хурдны мэдээллийг нэгтгэн анализ хийлээ. Агаарын температур: Төслийн талбайд өвлийн улиралд -8.69-(-15.36), хаврын улиралд 0.27-13.81°C, зуны улиралд 18-23.13 °C, намрын улиралд -5.27-16.51 °C хүрдэг байна. Тус мэдээнээс харахад жилийн дундаж температур нь 4.09-4.26 °C байгаа нь агаарын температурын зөрүү багатай байгааг илтгэнэ.

Хур тунадас: Төсөл хэрэгжиж буй талбайн сарын нийлбэр хур тунадасны мэдээллийг харахад 1-3 сард хур тунадас унаагүй, дулааны саруудад буюу үйл ажиллагаа явагдах үед нийт жилд унах хур тунадасны 95% унадаг байгаа нь арай давамгай байна. Өвөл, хавар, намрын саруудад 5.0% хувийг эзэлж байгаа нь ажиглагдаж байна. 2021 онд тус талбайд өмнө онуудаас 1-5 дахин их хур тунадас унасан ажиглагдаж байна. Салхины хурд: Төслийн талбайн салхины хурд нь жигдийн төлөвтэй байх ба жилийн дундаж хурд нь 4.5-4.8 м/сек байна.

3.3 Гадаргын ус болон газрын доорх ус

Гадаргын усны сүлжээ: Тус төслийн талбай нь усзүйн хувьд Төв Азийн гадагш урсгалгүй Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газарт байрлаж байна. Тус сав газар нь газар нутгийн хувьд 8 аймгийн 59 сум, Улаанбаатар хотын 1 дүүргийн нутаг дэвсгэрийг хамран, нийт 178172.2 км² талбайтай буюу Монгол орны газар нутгийн 11.3

хувийг эзэлдэг. Сав газарт Багахангай дүүрэг болон аймгийн төв 3, сумын төв 37 багтана. Энд 1 дүгээр эрэмбийн сайр горхи 174, тэдгээрийн дундаж урт 2.2 км, дундаж ус хурах талбай 27.4 км², 2 дугаар эрэмбийн горхи 16 ба Жаргалант хэмээх 3 дугаар эрэмбийн гол байна. Жаргалант гол нь Батхаан уулын өврөөс усжих Өвөр Жаргалант, Уст уулын өврөөс эх аван урсах Ботгоны голын бэлчрээс Жаргалант хэмээн нэрлэгдэн Төв аймгийн Эрдэнэсант сумын ба Бүрэн сумын нутагт Төхөмийн нуурын хотгорт шургана. Жаргалант голын ус хурах талбай 473 км², урт нь 34 км, дундаж хэвгий 0.0116 байна.

Төслийн талбай орчмын гадаргын усны сүлжээ: Төслийн талбай байрлах Баянжаргалан суманд Зүүн гашуун булаг, Булаг элгэн, Хөөт, Хар толгой, Сэрвэн, Аргатай зэрэг 17 булагтай. Хавиргын улаан, Нэмнээгийн улаан, Энгэрийн улаан, Могойн улаан гэсэн дөрвөн том нуур байдаг. Төслийн талбайтай хамгийн ойр орших гадаргын урсац нь төслийн талбайгаас хойш 0.6 орчим км-т урсах Гашуун булгийн рашаан байх ба булгийн эх нь төслийн талбайгаас хойш 1.9 км байрлаж байна.

Газрын доорх ус: Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар нь нь гадаргын усны сүлжээ хомс бөгөөд хүн амын унд ахуй, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлд зөвхөн газрын доорх усыг авч ашигладаг, гидрогеологийн хувьд муухан судлагдсан газар байрлаж байна. Гэвч гидрогеологийн ерөнхий нөхцөлөөрөө газрын доорх ус агуулагч үе, бүрдэл, бүс харьцангуй өргөн тархсан, газрын доорх усаар бийлэгжүү нутаг билээ.

Төслийн талбай нь Монгол орны гүний усны тэжээгдлийн мужлалаар <5 мм/жил тэжээгдлийн мужид хамаарч байна. Энэ нь төслийн талбай түүний орчны газрын доорх ус нөхөн сэлбэлтээр ядмаг болохыг илтгэнэ.

3.4 Хөрсөн бүрхэвч

Төслийн талбай нь хөрсний газарзүйн мужлалтаар (Монгол орны үндэсний атлас) хөрс-био уур амьсгалын Говийн их мужийн Цайвар хүрэн хөрсний дэд бүсийн Баяндэлгэрийн тойрогт багтана.

Дундговь аймгийн нутаг дэвсгэрт аллювийн хурдас, делювийн хурдас, алюви- делювийн хурдас, элювийн хурдас, эоловийн хурдас, нуурын хурдасууд тархсан байна. Мөн нутаг дэвсгэрийн хамгийн их талбайг буюу 53.2 хувийг делювийн хурдас эзэлж байна. Алюви-делювийн хурдас нийт нутаг дэвсгэрийн 36 хувийг эзэлж байна.

Хөх дэлийн хайлуур жоншний орд ашиглах төслийн талбайд толгодын хүрэн хөрс зонхилон тархсан.

3.5 Ургамлан нөмрөг

Хөх дэлийн хайлуур жоншны орд, түүний орчмын газар нутаг нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарагдана (Өлзийхутаг, Н., 1989). Тус тойрог нь тачир, сийрэг ургамалтай, хялгана-таанат өдлөг хялганат, хялгана-хазаар өвст цөлөрхөг хээр зонхилно. Нутаг дэвсгэрийн 9.35%-ийг эзэлдэг, 327 зүйл гуурст ургамалтай, түүний 68 зүйл нь модлог, сөөглөг, 259 нь зүйл өвслөг ургамал байна.

Хөх дэлийн хайлуур жоншны орд талбайд 13 овгийн 27 төрлийн 32 зүйл ургамал тус тус бүртгэгдсэн. Эдгээр ургамлууд нь амьдралын хэлбэрийн хувьд мод-1, сөөг-2, сөөглөг-1, сөөгөнцөр 1, сөөгөнцөрлөг-3, олон наст-15, хоёр наст-1, нэг наст-8 зүйл ургамал тус тус тэмдэглэгдсэн. Монгол улсын байгалийн ургамлын хуулиар хамгаалагдсан болон

бүс нутгийн улаан дансанд бүртгэгдсэн ховор статустай 1 зүйл, хээрийн бүсийн унаган-3, эмийн-3 зүйл ургамал байгалийн унаган төрхөөрөө ургаж буйг тэмдэглэлээ. Мөн талбайд бэлчээр, тэжээлийн үнэт ургамлуудаас *Agropyron cristatum*-саман Ерхөг, *Achnatherum splendens*-гялгар Дэрс, *Elymus chinensis*-нангиад Цагаан суль буюу түнгэ, *Cleistogenes songorica*-зүүнгарын Хазаар өвс, *Stipa gobica*-говийн Хялгана, *Stipa krylovii*-шивээт Хялгана, *Allium polyrrhizum*-таана Сонгино зэрэг ургамлууд тэмдэглэгдсэн.

3.6 Амьтны аймаг

Тус судалгааны талбайн нутаг дэвсгэр нь хөхтөн амьтны газар зүйн мужлалаар Хойт говийн тойрог, орнитогазарзүйн мужлалаар (Болд, 1989) Хойт говийн тойрогт хамаарагдаж байна. Судалгааны явцад тал хээрийн шувууд, цагаан зээр харьцангуй элбэг тохиолдож байлаа. Төсөл хэрэгжиж буй аймгийн нутагт Дэлгэрхангай, Их, бага газрын чулуу, Хулд, Хөнжил, Тайлагийн уул, Аргын хаданд аргаль, янгир бий. Үнэг, хярс, дорго, мануул, өмхий хүрэн зэрэг амьтад ихэнх сумдын нутгаар бий. Харин бартаа саад ихтэй уул хаданд чоно, мэр сэр орогнол, гүйгүүл маягаар амьдарна. Хойд талын сумдад тарвага байдаг, могой, могой гүрвэл, хонин гүрвэл зэрэг хэвлээр явагч, голио, царцаа, дэвхрэг, цох мэт шавж хорхой элбэг. Нутгийн хойд болон зүүн талын сумдын нутгаар цагаан зээр болон бор гөрөөс элбэг. Мөн ховор, шилүүс, хулан зэрэг амьтан байдаг.

Төсөл хэрэгжиж буй талбайн ойр орчимд цагаан зээр (*Procapra gutturosa*) сүрэг 10-20 бодгалиараа сүрэглэн тархан нутаглах нь элбэг байна.

3.7 Нийгэм эдийн засгийн үзүүлэлт:

Төслийн талбай нь дэд бүтэц харьцангуй сул хөгжсөн, хүн ам сийрэг суурьшсан бүс нутаг юм. Улсын чанартай төв зам төслийн талбайгаас хол өнгөрдөг ба орон нутгийн чанартай шороон замуудаар ойролцоох сумын төвүүдтэй холбогдоно. Нутгийн оршин суугчид нь халх ястан аж төрдөг. Хүн амын гол хөдөлмөр нь мал аж ахуй бөгөөд 5 хошуу малыг бүгдийг нь өсгөдөг онцлогтой. Гэвч сүүлийн жилүүдэд сүргийн бүтцийн дийлэнх хэсгийг бог мал, тэр дундаа ямаа эзэлж байгаа нь малын бэлчээрт сөргөөр нөлөөлж байгаа муу мэдээ байдаг. Сүүлийн жилүүдэд өвлийн улиралд зуд турхан болох нь нэмэгдэж байгаатай холбогдуулан орон нутгийн малчид өвөл, хавартаа бусад аймаг, бүс нутагт оторлон нутаглах нь эрс нэмэгдэж байгаа.

Сумын төв нь орон нутгийн чанартай шороон замаар холбогдох ба эмнэлэг, сургууль, харилцаа холбоо болон хувийн хэвшлийн үүрэн телефоны операторууд, ХААН, Хадгаламж банкны салбар, Петровис компаний болон бусад ШТС-ууд, хүнс, барааны дэлгүүр, зочид буудал үйл ажиллагаа явуулдаг. Сумын төвүүд нь бүгд өндөр хүчдэлийн шугамд холбогдсон байдаг.

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хайлуур жоншны ордын тухайн бүс нутагт шууд нөлөөлөл үзүүлэхээс гадна энэ процесс нь олборлолт явагдаж байхад болон олборлолтын дараа байгаль нөхөн сэргээлт хийсэний дараач сөрөг нөлөөлөл нь үргэлжилнэ. Сөрөг нөлөөллийн эрчим нь олборлолт эхэлсэнээс хойш ихсэнэ. Төслийн үйл ажиллагааны улмаас уулын чулуулгийн тогтоц, агаарын чанар, гүний усны хэмжээ, чанар өөрчлөгдөх, хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөллүүд байна.

4.1 Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

Ордыг ашигласнаар газрын гадаргууг өөрчлөхөөс гадна хөрсний бүтэц, дүүргийн гидрогеологийн горимыг өөрчилдөг.

4.2 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

Хайлуур жоншны ордыг олборлох, тээвэрлэх явцад машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий гэх мэт/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ ихсэх зэргээр агаарын хими болон физик шинж чанарт нь сөрөг нөлөөлөл үзүүлэх болно.

Ил уурхайн аргаар ашигт малтмал, эрдэс түүхий эдийг олборлоход агаарт их хэмжээний тоос гарах нөхцөл бүрддэг. Бульдозер, ачигч зэрэг машин механизмуудаар хөрсийг хуулах овоолго хийх, түүхий эдийг бутлах, ачих зэрэг технологийн процессийн явцад салхитай нөхцөлд тоос ихээр гарч агаарыг бохирдуулах нөлөө үзүүлнэ.

4.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хөрсийг бохирдуулснаас гадаргын болон гүний усанд шууд бусаар нөлөөлнө.
- Гүний усны нөөц хомсдох

4.4 Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг дурдвал:

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас болон хүний анхаарал болгоомжгүй байдлаас шатахуун, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- Уурхайд хөрсний овоолго хийх, жонш, хөрс тээвэрлэх зэрэг үндсэн үйл ажиллагаанд хүнд даацын олон машин ажиллахад хөрс их хэмжээгээр элэгдэл, эвдрэлд орж, хөрсний үржил шим алдагдана.
- Жонш, хөрс тээвэрлэх явцад талбайд элдэв хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, дагтаршсан шороон хэсэг суларч цас борооны усанд

норж шавар шалбааг ихтэй, хуурай, салхитай үед тоос шороо босч орчныг
бохирдуулах зэргээр нөлөөлнө.

- Хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах, хуурайших.

Төслийн үйл ажиллагаанаас дараах байдлаар ургамлын нөмрөгт нөлөөлнө. Үүнд:

- Хог хаягдал салхиар дамжиж тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамал, хөрс, гүний усыг бохирдуулах нөхцөл болно,
- Газар шорооны ажлын үед ургамлын үе хөрсийг хуулах,
- Хөрс хуулах, хөрсний овоолго хийх,

Төслийн явцад бусад зориулалтаар газар ашиглахад ургамлын төрөл зүйл устаж үгүй болох, хувьсаж өөрчлөгдөх сөрөг нөлөөлөлтэй.

4.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

Жоншны ордыг ашиглах төсөл хэрэгжүүлэх хугацаанд хүн, машин техникийн дуу чимээ, хөдөлгөөн нэмэгдсэнээс үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн зэрлэг амьтдад шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, бэлчээр, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай. Төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь дараах хүчин зүйлсээр тодорхойлогдоно. Үүнд:

- Техникийн осол аваар
- Ухсан нүхэнд мал, амьтан унаж осолдох

Уурхайн үйл ажиллагааг зохион байгуулалттай явуулж, тээвэрлэлтийн замыг олон салаалуулалгүй, тэмдэг тэмдэглэгээгээр удирдан хязгаарлах нь нутгийн газар ба хөрс, ургамал, амьтдыг хамгаалах нэгэн төрлийн арга хэмжээ болно.

4.6 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:

- Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд байнгын хяналт тавиагүйн улмаас үйл ажиллагаа зогсох, ажилчид гэнэтийн осолд өртөх
- Ажилчдын ажлын байрны аюулгүй орчин бүрдэхгүй, хүнд нөхцөлд ажиллах.

БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ийн “Хөх дэл” хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө оршино.

“Хөх дэл” нэртэй хайлуур жоншны ордыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан.

Энэхүү БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **26,868,000** төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулин дээрх шаардлагын дагуу “Хөх дэл” хайлуур жоншны ордын үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсрууллаа.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Хөх дэл” хайлуур жоншны ордын үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМНЕТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэм-жих нэгж	Нэгжийн зардал, төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг, / 2026 он /	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	-Ил уурхайн олборлолтын үед тоосжилт үүсэх, -Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт,	Уурхайн дотоод зам талбайн усалгааг цаг агаарын нөхцөл байдал, уурхайн ашиглалт тээвэрлэлттэй уялдуулан тогтмол гүйцэтгэх. Мөн тоосжилт дарах усалгаанд шүүрлийн усыг ашиглаж усалгаа хийх.	Зам талбай	м ²	40.000м ²	800м ³ /жил	1,000.000	5-9 сард	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 4585:2007. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 3384:1982. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,
2		Уурхайд ашиглагдах бүхийл тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд тогтмол хамруулан, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд тухай бүрт засварлах арга хэмжээг авах	Тээврийн хэрэгсэл	-	50,000	10	500,000	Жил бүр	

3		Олон салаа зам гаргахгүй байхаар уурхайн зам дагуу MNS 4597:2014 стандартыг хангасан замын тэмдэг байршуулах	Зам талбай	-	-	-	Дотоод төлөвлөлт- өөр	2026 онд	
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч									
1	-Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хөрс элэгдэл эвдрэлд өртөх, - Олборлолт,тээвэ рлэлтийн замд арчилгаа хийх -ШТМ асгарч газрын гадарга хөрсийг бохирдуулах.	2 жилээс дээш хэмжээгээр хадгалах шимт хөрсний овоолгыг хэлбэршүүлэх, салхинд хийсэхээс сэргийлж ургамалжуулах	Шимт хөрсний овоолго	-	-	-	Дотоод төлөвлөлт- өөр	Уурхайн үйл ажиллагаа- ны үед	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага, - MNS 3310-91, Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох, - MNS 17.5.1.19-92, БОХ. Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах шаардлага, - MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
2		ШТМ хөрсөнд алдагдсан үед нэн даруй саармагжуулах арга хэмжээ авах мөн саармагжуулах	ШТМ	-	-	-	300,000	Тогмтол	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага, - MNS 3310-91,

3		Олборлолт, тээвэрлэлтийн замын зам арчилгааг сайжруулах	Зам талбай	-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	2026 онд	Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох, - MNS 17.5.1.19-92, БОХ. Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах шаардлага, - MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
4		Машин механизмын засвар үйлчилгээ хийх талбайд бетон хучилт хийх	Уурхайн засварын талбай	м²	-	900м²	2,000.00	2026 онд	
Усан орчин									
	Усны нөөцийн хомсдол болон түүний түвшинг тогтоох	Уурхайн шүүрлийн усыг зумпын аргаар цуглуулан татаж зам талбайн тоосжилт дарах зорилгоор ашиглах мөн ногоон байгууламжийн усалгаанд ашиглах	Шүүрлийн ус	-	-	-	1.000,000	2026 онд	-
		Гүний худгийг шинээр байгуулах	Гүний худаг	-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	2026 онд	-
Амьтан									
1	-Уурхайн олборлолтын үед	Уурхайн олборлолтын үйл ажиллагааг өдрийн цагаар /7-22 цаг/ олон тоног	-	ш	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	2026 онд	-Амьтны тухай хууль

	амьтад үргэн дайжих, -Хууль бус ан амьтан хийх.	төхөөрөмж ажиллуулахгүй байх зарчмыг баримтлан ажиллах							
2		Уурхайн ухашыг хашаалан мал, амьтан унаж бэртэх эрсдлээс сэргийлэх	-	ш	-	-	800,000	2026 онд	
Нийт зардал							5.600.000		

6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2026 оны олборлолтын үйл ажиллагааны явцад техникийн нөхөн сэргээлт болон биологийн нөхөн сэргээлт хийгдэх талбай байхгүй юм. Учир нь ордын нөөцийн хил нь өмнө нь ашиглаж байсан карьер болон овоолготой давхцаж байгаа тул энэхүү талбайд 2026 онд олборлолтын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн байна.


6.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Флюмон” ХХК нь Байгаль орчины менежментийн төлөвлөгөөний хүрээнд 2026 онд “Хөх Дэл”-ийн ордын ойролцоо Дундговь аймгийн Баянжаргалан сумын удирдлага болон байгаль орчны мэргэжилтэнтэй хамтран ашиглалтгүй болсон эвдэгдсэн талбайд дүйцүүлэн нөхөн сэргээх талбай нийт 0.51 га газарт техникийн нөхөн сэргээлт хийнэ.

Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2026 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутагтай хамтарч ажиллах, дүйцүүлэн хамгаалах ажил хийх санал орон нутгаас авах, хэрэгжүүлэх.	0.51 га газрыг нөхөн сэргээх	0.51 га	-	5.000.000	2026 онд	-Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэх гарын авлага, -БОНБНУ-ий тухай хууль.
3		Орон нутгийн тусгай хамгаалалтай газарт био техникийн арга хэмжээ авах	-	-	3'000'000	2026 онд	
5	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих	Төслийн талбай орчимд 500 ш мод тарина.	500ш	-	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.	2026 онд	
Нийт зардал					8.000.000		

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах “Хөх дэл” хайлуур жоншны ордын
Зүүн үнэгт талбайн ил уурхайн төслийн 2026 онд Дүйцүүлэн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн талбайн байршлын зураг



Зураг 3. Дүйцүүлэн нөхөн сэргээлт хийх талбайн байршлын зураг



“Хөх дэл” хайлуур жоншны ордын Зүүн үнэгт талбайн ил уурхайн төслийн 2026 онд
биологийн нөхөн сэргээлт, ногоон байгууламж бий болгохоор төлөвлөсөн талбайн байршлын зураг



Зураг 4. Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих талбайн байршил

6.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт харъяалагддаг бөгөөд төслийн нөлөөллийн талбайд айл өрх суурьшаагүй учраас нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал үүсэхээргүй байна.

6.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн түүх, археологийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

6.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2026 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	-Гамшгийн эрсдэл үүсэх. -Галын гэнэтийн аюул үүсэх, -Ажилчид бэртэх, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх.	Гэнэтийн хүчтэй шороон болон цасан шуурга болоход байнгын бэлэн байдалд байж уурхайн талбайд ил задгай замбраагүй тоног төхөөрөмж байршуулахгүй байхад анхаарах	Ажилчдад	-	-	Мэргэжлийн байгууллагатай тохиролцох	Жил бүр	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) -MNS6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт, ерөнхий анги, -MNS 5002 2000: Хөдөлмөрийн
2		Кемпийн орчимд тамхины цэг байгуулах	Уурхайн ажилчид	1	-	1,000,000	Тогтмол	
3		Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, багаж хэрэгслийг нэмэгдүүлэх, сайжруулах	Уурхайн кемп орчимд	-	-	1,000,000	2026 онд	

4	-Уурхайд тэсэлгээний үед аюул үүсэх.	Ажилд гарахын өмнө ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	ХАБ мэргэжилтэн	-	-	-	Өдөр бүр	аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй -MNS 12.4. 005 – 1985: Хөдөлмөр хамгаалал.Шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд.
5		Аваар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж ажиллах	Уурхайн удирдлага	-	-	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	
6		Тэсэлгээг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх.	Тэсэлгээ	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2026 онд	
7		Уурхайн тэсэлгээний үед аюулгүй ажиллагааг сайтар мөрдөж ажиллах		-	-	-	2026 онд	
Нийт зардал						2.000.000		

6.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хайлуур жоншны ордын ашиглалттай холбогдож гарах хог хаягдлын хяналт, удирдлага, зохион байгуулалтыг оновчтой шийдвэрлэх зорилгоор журам боловсруулж мөрдөнө. Уг зорилтын хүрээнд хог хаягдал, байгаль орчны талаарх Монгол Улсын хууль, бодлого шийдвэр, дүрэм журмын дагуу, Олон улсын уул уурхайн үйл ажиллагаанд шалгарсан дэвшилтэт арга технологиудыг судална.

Хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах арга хэлбэр: Тус уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас гарах технологийн хатуу хог хаягдал нь олборлолтын явцаас гарах нарийн ширхэгт хөрс, шороо. Тус хаягдлыг уурхайн нөхөн сэргээлтэд эргүүлэн ашиглана. Үйлдвэрийн гаралтай металл хаягдлыг тусгай талбайд хурааж, тээвэрлэж, 2-догч түүхий эд болгон борлуулах арга хэмжээг авна.

Мөн ажиллагсдын байрлах байрнаас хатуу хог хаягдал гарна. Үүнийгээ тусгай зориулалтын тагтай саванд хадгалж байгаад тээвэрлэн сумын захиргаатай гэрээ байгуулан тогтмол хугацаанд заасан хогийн цэгт зайлуулна. Ахуйн хаягдал цуглуулах цэгийн ашиглалтыг сайжруулах, хашаалах, хуучин хаягдлын нүхийг дарж булж, овоолго шороог нэгтгэж эмхэтгэх.

Хог хаягдлын менежментийн хүрээнд хуванцар хог хаягдал, цаасны хог хаягдал болон ердийн хог хаягдал зэргээр ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэр цэгүүдтэй хамтран ажиллаж хог хаягдлыг боловсруулах ажлыг нэвтрүүлж ажиллах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Шингэн хаягдал цэвэрлэгээ, арга хэлбэр, зайлуулалт: Ахуйн шингэн хаягдлыг тусгай бэлтгэсэн бохирын цооногт хаяхын зэрэгцээ шингэн бохирдол хөрсөнд нэвчихээргүйгээр тусгаарлах, засаж тохижуулж үнэр болон бусад сөрөг нөлөөлөл үүсэхээс урьдчилан сэргийлж байгуулна.


Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг /2026 он/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2		Хог хаягдлын гэрээ байгуулан, гэрээний дагуу хог хаягдлыг төвлөрсөн цэгт зөөж зайлуулах	Хог хаягдлын гэрээ	-	-	-	960,000	Жил бүр	
3		Ахуйн хог, хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын хогийн сав байршуулах Энгийн хатуу хог хаягдлын цэг дээр галд тэсвэртэй материалаар, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хогийн сав байрлуулах	Зориулалтын хогийн сав	-	-	-	2,000,000	2026 онд	

4		Дахин ашиглах боломжтой хоёрдогч түүхий эдийн хог хаягдлыг зориулалтын газар цуглуулах, хоёрдогч түүхий эдийн цэгт тушаах	Дахин ашиглах боломжтой хог хаягдал	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	
6		Уурхайн орчин болон тээвэрлэлтийн зам дагуух цэвэрлэгээг тогтмол хийх	Хог хаягдал	-	-	-	-	Тогтмол	
8		Уурхайн талбайд байгальд ээлтэй био 00 байршуулах	Био 00	ш	-	2	5,000.000	8-р сард	
9		Ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийх	Ариутгал хийх		60,000	-	120,000	Жилд 2 удаа	
10	Аюултай хог хаягдал	Ашигласан шатах, тослох материалыг зориулалтын саванд /Поошик/ хадгалах, уурхайн орчинд асгарч алдагдахаас тухай бүр сэргийлэх, ШТМ дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх, бүртгэл хөтлөх	ШТМ-ын хаягдал	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2026 онд	
11		Уурхайн талбай дээр байгаа төмрийн хаягдлыг зориулалтын газар цуглуулж, цэгцлэх.	Төмрийн хаягдал, ШТМ-ын хаягдал	-	-	-	-	2026 онд	
Нийт зардал							8.080.000		

6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан чухал баримт бичиг юм.



Зураг 5. ОХШХөтөлбөрийн мониторингийн цэг

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал, төг	Нийт зардал, төг / 2026 он /	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаарын орчин							
1	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээ хийлгэх	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэгээс, зонхилох салхины доод ба дээдт талд -Уурхайн карьерт -Тээвэрлэлтийн зам.	Жилд 2 удаа	Агаарын сорьц дээж 60,000 Агаарын шинжээч томилолтын зардал - 150,000	540,000	Баягаль орчин хэмжилзүйн төв лабораторит	-MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, -MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга
Хөрсөн бүрхэвч							
1	Агрохимийн шинжилгээ: Хөрсний химийн үзүүлэлт (pH, EC _{2.5} dS/m, P ₂ O ₅ , K ₂ O, CaCO ₃)	-Кэмпийн талбай -Шимт хөрсний овоолго, -Ил уурхайн орчимд	Жилд 2 удаа	30,000	180,000	Итгэмжлэгдсэн хөрсний шинжилгээний лаборатори	-MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар.
2	Хөрсний хүнд металлын шинжилгээ: (Cr, Cd, Pb, Ni, Co, Cu)	- ШТМ-н агуулах орчимд - Хогийн цэгийн орчимд	Жилд 2 удаа	33,000	132,000		Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох.

Усан орчин							
1	Усны химийн ерөнхий шинжилгээ: (рН, ЕС, TDS) нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ (CaCO ₃)	-Унд ахуйн уснаас -Гашуун булаг	Жилд 2 удаа	56,000	224,000	Усны итгэмжлэгдсэн лаборатори	-MNS 3935:1986. Ундны ус хяналт шинжилгээнд тавих ерөнхий шаардлага, - MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус- химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх, -MNS4432:1997 Ундны ус. Өнгийг тодорхойлох арга, Усны нөөцийг бохирдохоос хамгаалах, MNS 4943 : 2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус.
2	Хаягдал уснаас дээж авч бохирдлыг хянах, усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ Үүнд: -Шүүрлийн ус - Хаягдал бохир ус	Шүүрлийн усыг уурхайн 1 ба 5-р хүдрийг биетээс гарч буй шүүрлийн усанд, Хаягдал усны дээжийг ахуйн бохир усны цооногоос	Жилд 2 удаа	Хаягдал усны шинжилгээ 1 дээж – 56,000төг Шүүрлийн усны шинжилгээ 2 дээж – 100,000төг	312,000		
Нийт зардал					1,388,000		

6.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон Төсөв / 2026 он /	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 онд				
			6-р сар	7-р сар	8-р сар		
1	Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	60,000 * 30=1,800,000		+		Уурхайн удирдлага	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх шаардлагатай.

2	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээг шинэчлэн байгуулж, гэрээний дагуу хамтран ажиллах, шинэчлэх	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	Уурхайн удирдлага	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан нягт хамтран ажиллах
3	Төслийн талбай орчмын иргэдийн санал хүсэлтийг харгалзан багийн иргэдийн тулгамдаж буй асуудлыг шийдэж өгөхөд туслах	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	Уурхайн удирдлага	Нөлөөллийн бүсийн айлуудыг саналыг авч тусгах шаардлагатай.
4	Байгаль орчны аудитын тайлан хийлгэх	Мэргэжлийн байгууллагатай тохиролцох		+		Уурхайн удирдлага	-
Нийт зардал		1.800.000					

6.10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт 13. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Дундговь аймаг	Орон нутгийн байгаль орчны газар	Тайлан хэлбэрээр, уурхайн талбайд очих.	БОМТ-ийн 2026 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ны өдрийн дотор	Уурхайд
БОУАӨЯ	БОУАӨЯ-ны ХБОБНУГ	Тайлан			БОУАӨЯ - ны ХБОБНУГ-т
Төрийн захиргааны төв байгууллага	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр	2026 оны БОМТ	12-р сарын 01-ны өдрийн дотор	-

2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

2026 онд БОМТ-нд нийт **26,868,000** төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 14. 2026 оны БОМТ-нд зарцуулах нийт зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2026 он /төгрөг/
1	Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	5,600,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	8,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	8,080,000
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,000,000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1,800,000
9	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө	-
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,388,000
Нийт дүн		26,868,000

ДҮГНЭЛТ

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ийн “Хөх дэл” хайлуур жоншны ордын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг боловсруулж дараах дүгнэлтэд хүрлээ.

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ийн 2026 оны БОМТ-ний биелэлтийн тайланг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Уг төслийн явцад байгаль экологийн унаган төрхийг хамгаалахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг мөрдлөг болгон ажиллаж, 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчны арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

“Хөх дэл” хайлуур жоншны ордын БОМТ-нд 2026 онд нийт **26,868,000** төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх үүрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” БОАЖСайдын А/618 тоот тушаал, 2019 он.
5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014
6. Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Хөх дэл” хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2023 он
7. <http://www.legalinfo.mn//>